2025 он 06 сар 19 өдөр Дугаар 27 Улаанбаатар хот

***Андеррайтерийн үйлчилгээний гэрээ байгуулахыг зөвшөөрөх тухай***

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.7.15 дахь заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

**1.** Говь ХК нь биржийн бус зах зээлд үнэт цаас /өрийн хэрэгсэл/ гаргах, хөрөнгө оруулалт татахад Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх компаниар "Таван Богд Капитал ҮЦК" ХХК-г сонгож, дараах нөхцөлөөр гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй. Үүнд:

| | |
|---|---|
| Өрийн хэрэгслийн төрөл | Хаалттай бонд / Биржийн бус зах зээл |
| Нийт татан төвлөрүүлэх дүн | 20,000,000,000 /хорин тэрбум/ төгрөг |
| Бондын хугацаа | 12 сар |
| Жилийн хүү | 8.0-11.0% |
| Андеррайтерийн төлбөр | Бондын татан төвлөрүүлсэн үнийн дүнгээс 2% шимтгэл буюу 400,000,000 /дөрвөн зуун сая/ төгрөг |

**2.** Андеррайтерийн үйлчилгээний гэрээ, хэлцэл болон бусад холбогдох баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д олгосугай.

**3.** Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн батлалсугай.

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТТН2998 ... 2076357

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД: ............ Д.ГЭРЭЛМАА

............ А.ЖАРГАЛМАА

............ Д.ХҮРЭЛБААТАР

20 25 он 07 сар 04 өдөр Дугаар 28 Улаанбаатар хот

***Үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай***

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 41.3, 41.5, 76 дугаар зүйлийн 76.1.5 дахь заалт болон Говь ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг тус тус удирдлага болгон "Говь" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

**1.** Дахин санхүүжилт болон хөрөнгө оруулалт хийх зорилгоор Говь ХК-аас 20,000,000,000 /хорин тэрбум/ төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаас /өрийн хэрэгсэл/-ыг дараах хөтөлбөр, нөхцөлийн дагуу гаргахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй. Үүнд:

| **Үнэт цаас гаргагч** | **"Говь" ХК** |
|---|---|
| Үнэт цаасны төрөл | Өрийн хэрэгсэл /бонд/ |
| Гаргаж буй зах зээл | Биржийн бус зах зээл /Over-the-Counter Market/ |
| Нийт татан төвлөрүүлэх дүн | 20,000,000,000 төгрөг |
| Санал болгож буй үнэт цаасны тоо | 20,000 ширхэг |
| Бондын нэрлэсэн үнэ | 1,000,000 төгрөг |
| Бондын хугацаа | 12 сар |
| Бондын нөхцөл | Бүрэн хөрвөх чадвартай |
| Жилийн хүү | 8.0-11.0% |
| Хүүгийн төрөл | Тогтмол хүүтэй |
| Хүү төлөх давтамж | Улирал бүр |
| Үндсэн төлбөр төлөлт | Хугацааны эцэст |
| Транч | Хөтөлбөрийн хүрээнд "Говь" ХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалаар тухай бүр тодорхойлно. |
| Үүргийн гүйцэтгэл хангуулах арга | "Таван Богд Холдингс" ХХК-ийн баталгаа |
| Бондын зарцуулалт | Дахин санхүүжилт болон хөрөнгө оруулалт |
| Бонд гаргах хугацаа | Зохицуулагч байгууллагад бүртгүүлснээр хөтөлбөрийн дагуу |

**2.** Үнэт цаас гаргахтай холбоотой гэрээ, хэлцэл болон бусад холбогдох бүхий л баримт бичигт гарын үсэг зурж баталгаажуулах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д олгосугай.

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998 2076357

ТУЗ-ИЙН ДАРГА: Ц.БААТАРСАЙХАН

ТУЗ-ИЙН ГИШҮҮД: Б.АМАРСАЙХАН

"Говь" ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17062, Монгол улс
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, И-мэйл: info@gobi.mn, Вэб сайт: www.gobi.mn

2025 он 07 сар 04 өдөр | Дугаар 28 | Улаанбаатар хот

........................ Д.ГЭРЭЛМАА

........................ А.ЖАРГАЛМАА

........................ Б.ОРГИЛ

........................ Ц.ОРГИЛБОЛД

........................ Д.ХУЛАН

........................ Д.ХҮРЭЛБААТАР

........................ Б.ЦЭЭНЯМ